

**МӨНГӨ УГААХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН
ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь мөнгө угаах, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн зорилгод арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох болон хориглох, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх, мэдээллийн нууцлалыг хадгалах, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Хөгжил Финанс ББСБ-ын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр болон холбогдох бусад журмын хүрээнд зохицуулагдана.
- 1.3 Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан Монгол Улсад хамааралтай тогтоолд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалт, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг дагаж мөрдөнө.
- 1.4 Энэ журамд орсон дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.4.1 “Мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;
 - 1.4.2 “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;
 - 1.4.3 “Терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;
 - 1.4.4 “Бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглаж хийсэн гүйлгээг;
 - 1.4.5 “Бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг;
 - 1.4.6 “Тохиолдлын гүйлгээ” гэж данс нээлгээгүй эсхүл тогтвортой бизнесийн харилцаа үүсгээгүй этгээдийн нэг удаагийн шинжтэй гүйлгээг;
 - 1.4.7 “Сэжигтэй гүйлгээ” гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, эсхүл мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзсэн гүйлгээг;
 - 1.4.8 “Санхүүгийн мэдээллийн алба” /цаашид СМА гэх/ гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монголбанкн дахь нэгжийг;
 - 1.4.9 Эрх бүхий байгууллага гэж гүйцэтгэх ажил болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих эрх бүхий прокурорын байгууллагыг;
 - 1.4.10 “Мэдээлэх үүрэгтэй этгээд” гэж Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг СМА-д мэдэгдэх үүрэгтэй буюу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу хяналт

- тавих байгууллагуудыг;
- 1.4.11 “Виртуал хөрөнгө” гэж аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг;
- 1.4.12 “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” /цаашид ВХҮҮ гэх/ гэж Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа компанийг;
- 1.4.13 ГоАМЛ гэж Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь аливаа улс орны санхүүгийн системийн аюулгүй байдал болон тогтвортой үйл ажиллагаанд заналхийлж, эдийн засгийн үр өгөөжийг бууруулаад зогсохгүй улс орны засаглалын тогтолцоог сулруулдаг дэлхий нийтийн асуудал юм. Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас өөрийн гишүүн орнуудын Санхүүгийн мэдээллийн албадуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зориулж
- 1.4.14 “Эцсийн өмчлөгч” гэж
- а. Харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- б. Харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- в. Хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- 1.4.15 “Хориг арга хэмжээний жагсаалт” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг;
- 1.4.16 “Дотоодын жагсаалт” гэж үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотойгоор терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг;
- 1.4.17 “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхийг;
- 1.4.18 “Хөрөнгө царцаах” гэж аливаа хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнийг эрх бүхий этгээдийн шийдвэрээр албадан битүүмжлэх, хураан авах хүртэл хугацаанд захиран зарцуулах, шилжүүлэх, удирдах эрхийг хязгаарлахыг;
- 1.4.19 “Авилга” гэж албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил.
- 1.4.20 “Хээл хахууль” гэж бэлэн мөнгө, тодорхой үнэ шингэсэн хүний хэрэгцээ хангахуйц материаллаг эд зүйлс байдаг.

ХОЁР. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ, МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАХ

2.1 Харилцагчийг таньж мэдэх (ХТМ), харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах үйл ажиллагаа нь Хүснэгт 1, 2-т заасан шаардлагын дагуу хийгдэнэ.

Хүснэгт 1. Харилцагч нь хувь хүн бол

Харилцагчаас авах мэдээлэл	Нягтлах баримт бичиг
----------------------------	----------------------

Овог, эцэг/эх/-ийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорт, И-Монголиа болон ХУР системээс авсан лавлагаа
Өөрийн нэр	Иргэний үнэмлэх эсхүл паспорт И-Монголиа болон ХУР системээс авсан лавлагаа
Төрсөн огноо	Иргэний үнэмлэх эсхүл паспорт И-Монголиа болон ХУР системээс авсан лавлагаа
Регистрийн дугаар Иргэний бүртгэлийн дугаар	Иргэний үнэмлэх эсхүл паспорт И-Монголиа болон ХУР системээс авсан лавлагаа
Байнгын оршин суудаг газрын хаяг, холбоо барих утасны дугаар	Харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авахыг байгууллагын дотоод бодлогоор тодорхойлно.
Одоо оршин газрын хаяг, холбоо барих утасны дугаар	
Эрхэлж буй ажил, бизнес: 1. Бизнесийн чиглэл, цар хүрээг тодруулах 2. Ажлын газрын нэр, хаяг, албан тушаалыг тодруулах	
Өөр хэн нэг этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийж байгаа эсэхийг тодруулах	Хэрэв харилцагч нь хэн нэгнийг төлөөлж байгаа бол төлөөлүүлж байгаа этгээдийн мэдээллийг авна.

Хүснэгт 2. Харилцагч нь хуулийн этгээд бол

Харилцагчаас авах мэдээлэл	Нягтлах баримт бичиг
Нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээ /opendata.burtgel.gov.mn систем болон И- Монголиагаас лавлагаа авах/
Улсын бүртгэлийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээ /opendata.burtgel.gov.mn систем болон И- Монголиагаас лавлагаа авах/
Татвар төлөгчийн дугаар	Татварын байгууллагаас олгосон баримт, бичиг
Хувьцаа эзэмшигчид	Улсын бүртгэлийн гэрчилгээ, үүсгэн байгуулах баримт бичиг, шийдвэр, аж ахуйн нэгжийн дүрэм. /opendata.burtgel.gov.mn систем болон И- Монголиагаас лавлагаа авах/
Үйл ажиллагааны чиглэл	
Хуулийн этгээдийн бүтэц, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга танилцуулга	Харилцагчаас ямар хэлбэрээр гаргуулан авахыг байгууллагын дотоод бодлогоор тодорхойлно. /opendata.burtgel.gov.mn систем болон И- Монголиагаас лавлагаа авах/
Үйл ажиллагаа явуулдаг хаяг, холбоо барих утасны дугаар	
Эцсийн өмчлөгчийн мэдээлэл	Хэрэв эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдэд ямар нэг албан тушаал эрхэлдэггүй бол Хүснэгт 1-н дагуу бүх мэдээллийг авах ба эцсийн өмчлөгч мөн болохыг нотлох баримтын хамт авна.

Хүснэгт 3. Харилцагч нь гадаад улсын иргэн, хуулийн этгээд бол

Харилцагчаас авах мэдээлэл	Нягтлах баримт бичиг
Хүснэгт 1, 2-т дурдсан харилцагчаас авах мэдээлэл болон бусад мэдээлэл	Терроризмтой тэмцэх зөвлөлөөс гаргасан жагсаалтыг албан ёсны цахим хуудас https://www.amlcft.mn/sanction -д байршуулсан хориг арга хэмжээний жагсаалттай тулган баталгаажуулна.

2.2 Мэдээлэх үүрэгтэй этгээд “ВХҮҮ-д хийх харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа болон эцсийн өмчлөгчийг таньж мэдэхдээ дараах үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1 ВХҮҮ нь нэг удаагийн болон 24 цагт хийсэн хэд хэдэн арилжааны нийлбэр дүн 3,0 сая төгрөг болон түүнээс дээш мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн гүйлгээ үнийн дүнтэй тэнцэх виртуал

- хөрөнгийн гүйлгээ хийхийн өмнө харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэднэ;
- 2.2.2 ВХҮҮ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй гэж үзсэн виртуал хөрөнгийн хаягийн “хар жагсаалт”-ыг боловсруулж харилцагчийн хэтэвчний хаягийг “хар жагсаалт”-тай тулган байнгын хяналт тавина;
- 2.2.3 ВХҮҮ нь IP хаяг, газарзүйн байршлын мэдээлэл, хэтэвчний хаяг болон гүйлгээний дугаар, хөрөнгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл, бүртгэл, тусгай зөвшөөрөл зэрэг нэмэлт мэдээллүүдийг хянана.
- 2.3 Харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн гүйлгээ, харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах үйл ажиллагааг зээлийн мэргэжилтэн, нягтлан бодогч, хэрэгжүүлэх бөгөөд салбарын захирал, ерөнхий нягтлан бодогч, комплайнс хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.
- 2.4 ББСБ нь дараах тохиолдолд харилцагчийн мэдээллийг дахин тулгаж шалгана:
- 2.4.1 Харилцагчийн 24 цагийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн дүн нь бага боловч нийт үнийн дүн 20,0 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ түүнээс дээш үнийн дүнтэй бол.
- 2.4.2 Дансгүй эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдын чанартайгаар 20,0 сая төгрөг / түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш хэмжээний гүйлгээ хийхийн өмнө
- 2.4.3 ВХҮҮ-ийн хувьд зохицуулалтгүй ВХҮҮ, бүртгэлгүй хэтэвч /unhosted wallet/ хооронд хийсэн гүйлгээг.
- 2.4.4 Өмнө нь авсан харилцагчийн мэдээлэл нь ББСБ-д санхүүгийн харилцаа болон гүйлгээний шинж чанар, зорилгыг ойлгож тодорхойлоход хангалтгүй байвал.
- 2.4.5 Тухайн харилцагч, тухайн гүйлгээг мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.
- 2.5 ББСБ харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийн үнэн бодит байдлыг тулгаж шалгах, харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй эсхүл харилцагч шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд тухайн ББСБ нь гүйлгээ хийх, данс нээх, санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх, бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах, эсхүл бизнесийн харилцааг зогсоох арга хэмжээ авна.
- 2.6 НҮБ болон дотоодын эрх бүхий байгууллага террорист гэж зарласан этгээдэд данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн аливаа үйлчилгээ үзүүлэхгүй.

ГУРАВ. САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 3.1 МҮЭ нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17, 3.1.18-д заасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 3.2 Зээлийн мэргэжилтэн нь сэжигтэй харилцагчийн мэдээллийг тагнуулын байгууллага, Терроризмтой тэмцэх зөвлөлөөс гаргасан жагсаалтыг албан ёсны цахим хуудас <https://www.amlcf.tn/sanction> -д байршуулсан хориг арга хэмжээний жагсаалт болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдтэй шууд, эсхүл шууд бусаар холбоотой аливаа харилцагч, гүйлгээ, гэрээ, хэлцэл, хөрөнгө, мөнгө байгаа эсэхийг шалгана.
- 3.3 МҮЭ хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, тэдгээрийн нэрийн өмнөөс шууд, эсхүл шууд бусаар, эсхүл тэдгээрийн зааврын дагуу үйл ажиллагааг явуулж байгаа этгээдийн хөрөнгө, мөнгө байгаа гэж мэдсэн даруйд харилцагчид урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай тагнуулын байгууллага, СМА-д даруй 24 цагийн дотор мэдээнэ.
- 3.4 МҮЭ нь МУТС-тэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТС-тэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба шаардлагатай бол хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна.
- 3.5 МҮЭ нь зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:
- 3.5.1 Зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой холбоотой мэдээ, мэдээллийг төрийн байгууллагад даруй өгөх;
- 3.5.2 Террорист үйлдэл, үйл ажиллагаанд өдөөн хатгасан аливаа явуулга, суртал ухуулга, үзэл санаанд автахгүй байх;
- 3.5.3 Терроризмыг сурталчлах, олон нийтэд уриалах, нийтийн өмнө зөвтгөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх;

- 3.5.4 Терроризмоос сэргийлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулах, хохирол, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх.
- 3.6 Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүү, бусад бүх төрлийн үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хориглоно.
- 3.7 МҮЭ нь заасан мэдээллийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.2, 23.6-д заасны дагуу мэдээлнэ.

ДӨРӨВ. ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОГСООХ БОЛОН ХОРИГЛОХ

- 4.1 МҮЭ нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогын хөдөлгөөнийг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд мэдэгдэнэ.
- 4.2 МҮЭ нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсхүл түүнийг төлөөлж байгаа этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 4.3 МҮЭ-ээс дээрх 4.1, 4.2-т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг зогсооно.
- 4.3.1 Зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон хөрөнгө
- 4.3.2 Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг хяналтаа тогтоосон хөрөнгө
- 4.3.3 Энэ журмын 4.3.1, 4.3.2-т заасан хөрөнгөөс бий болсон хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн хөрөнгө
- 4.3.4 НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл
- 4.4 Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоосон хүн, хуулийн этгээдийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой төлбөр, хүүгийн болон бусад төлбөрийг мөн адил зогсооно.
- 4.5 МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 4.1.3-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд энэ журмын дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, түүнтэй холбогдсон бусад арга хэмжээ авсан бол энэ талаар тагнуулын байгууллага болон СМА-нд мэдээлнэ.
- 4.6 МҮЭ нь энэ журмын заасны дагуу тагнуулын байгууллага болон СМА-ны шаардсан нэмэлт мэдээллийг даруй гаргаж өгөх үүрэгтэй.

ТАВ. ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

- 5.1 Ерөнхий нягтлан бодогч нь 20,0 (хорин) сая төгрөг, (түүнтэй тэмцэх хэмжээний гадаад валют) түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний төлбөр тооцоо, виртуал хөрөнгийн гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 (таван) өдрийн дотор /goaml.mongolbank.mn/ ГоАМЛ порталар холбогдох маягт (Хавсралт 1)-ийг сонгон мэдээллээ бөглөн хадгалж, Комплайнс хариуцсан ажилтан тайланд хяналт хийсний дараа мэдээлнэ.
- 5.2 Зээлийн мэргэжилтэн, нягтлан бодогч нь харилцагчийн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг МУТС, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилготой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн эсхүл мэдсэн дараах сэжигтэй гүйлгээний тохиолдлуудад Комплайнс хариуцсан ажилтанд тэр даруйд мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:
- Харилцагчаас гаргуулан авсан баримт, мэдээлэл нь худал эсвэл хуурамч болох нь тогтоогдсон;
 - Мөнгөний гарал үүслийн талаар тодорхой тайлбар өгөхөөс татгалзсан;
 - Гүйлгээг хийлгэж буй жинхэнэ өмчлөгчийн талаар мэдээлэл задруулахаас зайлсхийсэн;
 - Гүйлгээ, түүний агуулга, утгын талаар эргэлзээтэй тайлбар хэлэх;
 - Данс нээсний дараа харилцагчийн гэрийн, эсвэл ажлын утасны дугаар нь холбогдохгүй байх;
 - Харилцагч худал, хуурамч мэдээлэл өгсөн нь тогтоогдсон;
 - Харилцагч биеэр ирэлгүйгээр санхүүгийн үйлчилгээ авахыг оролдох, тулган шаардах;
 - Харилцагч санхүүгийн байгууллагын ажилтанд сэжигтэй, хэвийн бус гүйлгээг хийж өгсөн тохиолдолд мөнгөн болон бусад шагнал амлах, гүйлгээ хийхийг тулгаж шаардах;

- Харилцагч гүйлгээг мэдээлэх босго дүн, баримт, материал хадгалах шаардлага, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанаас зайлсхийх зорилгоор гүйлгээний дүн, бүтцийг өөрчилсөн;
 - Харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийн үнэн бодит байдлыг тулгаж шалгах, харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй эсхүл харилцагч шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан;
 - Харилцагчийн нэр террорист гэж зарласан этгээдүүдийн нэртэй тохирсон.
- 5.3 Комплайнс хариуцсан ажилтанд мэдээллийг нягтлан шалгаж, уг гүйлгээг сэжиглэх гүйлгээтэй холбогдох дараах нэмэлт мэдээллийг 24 цагийн дотор ГоАМЛ порталтаар Сэжигтэй гүйлгээний тайлангийн холбогдох маягтыг сонгон бөглөөд Гүйцэтгэх захиралд танилцуулж СМА-д ирүүлнэ:
- 5.3.1 Сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар
- 5.3.2 Сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн зээл судлуулахад ашигласан болон холбогдох бичиг баримтын хуулбар
- 5.3.3 Мэдээлэх үүрэгтэй этгээдийн харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг
- 5.3.4 Холбогдох бусад нэмэлт мэдээлэл
- 5.4 Комплайнс хариуцсан ажилтан 3.2 заасны дагуу мэдээлсэн сэжигтэй гүйлгээтэй холбоотой шинэ мэдээлэл, өмнөх тайлангаар мэдээлээгүй үйл ажиллагаа, гүйлгээний хэв шинжийн өөрчлөлт, өөрчлөгдсөн нөхцөл байдал болон мэдээлснээс хойш болсон үйл явдлын талаарх мэдээллийг Сэжигтэй гүйлгээний маягтаар дахин ГоАМЛ порталтаар холбогдох маягтыг сонгон мэдээлнэ.
- 5.5 Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэхэд ямар нэгэн хязгаарлалт, үнийн дүн хамаарахгүй. Комплайнс хариуцсан ажилтан нь байгууллага болон тайлан хариуцсан ажилтан буюу ЕНБ хэрэглэгчээр ГоАМЛ порталд бүртгүүлсэн байна. Тайлан хариуцсан хэрэглэгчээр бүртгүүлсэн ажилтан солигдсон үед шинэ хэрэглэгч бүртгүүлж, өмнөх хэрэглэгчийн эрхийг хаах арга хэмжээг авна.
- 5.6 Комплайнс хариуцсан ажилтан илгээсэн тайлан ГоАМЛ порталд илгээсэн тайлангийн төлөв, СМА-аас хүргүүлсэн мэдээлэл авах хүсэлт болон бусад и-мэйлүүдийг тогтмол шалгаж байх шаардлагатай.
- 5.7 ГоАМЛ порталд алдаатай тайлан оруулснаа тайлан хянагдаагүй үед мэдсэн бол СМА-тай холбогдож, хянагдаагүй буцаалгаж, засаж оруулах арга хэмжээ авна.
- 5.8 ГоАМЛ порталд алдаатай тайлан оруулснаа тайлан хянагдсаны дараа мэдсэн бол тайланг дахин оруулах хүсэлтийг СМА-ны fiu@mongolbank.mn хаяг руу илгээнэ. Тайланг дахин оруулах хүсэлтэд тайланг мэдээлсэн огноо, тайлангийн дугаар, тайлангийн нэр, гүйлгээний нийт тоо болон ямар учир шалтгаанаар тайлан дахин оруулах хүсэлт гаргаж байгаа талаар тодорхой бичсэн байна.
- 5.9 Комплайнс хариуцсан ажилтан сэжигтэй гүйлгээтэй холбогдох нэмэлт мэдээлэл авах хүсэлтэд ажлын 5 өдрийн дотор ГоАМЛ порталд хариу өгнө. СМА-аас хүргүүлсэн нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг ГоАМЛ порталд шалгаагүй нь дээрх 5 хоногийг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 5.10 20,0 сая төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээ болон сэжигтэй гүйлгээний тайланг илгээх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд комплайнс хариуцсан ажилтан энэ талаар СМА-ны fiu@mongolbank.mn цахим хаягруу нэн даруй мэдэгдэнэ.

ЗУРГАА. БАРИМТ МАТЕРИАЛЫГ ХАДГАЛАХ

6.1 ББСБ нь баримт материалыг дараах байдлаар хадгална:

Баримтын төрөл	Хадгалах хугацаа
Харилцагчийн данс нээх, бизнесийн харилцаа үүсгэхэд ашигласан бичиг баримт, харилцагчийг таньж мэдэх хүрээнд олж авсан бичиг баримтууд, биеийн байцаалтын хуулбар.	Данс хаагдсанаас эсхүл бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил. Тохиолдлын чанартай гүйлгээ хийсэн бол гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил. ВХҮҮ-ээс хойш 10-аас доошгүй жил.

Харилцагчийн мэдээллийг нарийвчлан шалгах явцад олж авсан баримт, мэдээлэл. Харилцагчийн мэдээлэлд орсон өөрчлөлт, нэмэлт баримт, мэдээлэл, дансны мэдээлэл, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлоход ашигласан мэдээлэл, харилцагчийг таньж мэдэх, тусгайлан хяналтын дүгнэлт, сэжигтэй гүйлгээтэй холбоотой баримт, материал.	Харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил. ВХҮҮ-ээс хойш 10-аас доошгүй жил.
Бэлэн болон бэлэн бус гүйлгээний баримтууд	Гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил. ВХҮҮ-ээс хойш 10-аас доошгүй жил.

- 6.2 Харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулан хадгалах бөгөөд мэдээлэлд орсон өөрчлөлтийг шинэчлэн хадгална.
- 6.3 Баримт материалыг тухайн гүйлгээтэй холбоотой мэдээллийг агуулсан, эрх бүхий этгээдийн шаардлагаар гаргаж өгөхөд бэлэн, аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангаж байхаар архивт хадгална.

ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 7.1 Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн тайлан, түүнтэй холбоотой нэмэлт мэдээлийн үнэн зөв, бодит байдалд гүйцэтгэх захирал хяналт тавина.
- 7.2 МҮЭ нь гүйлгээний талаарх мэдээлэл бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа, мэдээлсэн, шилжүүлсэн тухай мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг төрийн болон албаны нууцын тухай хууль болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу хадгална.
- 7.3 ББСБ нь СМА-д мэдээлэл ирүүлэх журамд заасны дагуу сэжигтэй гүйлгээний тайланг мэдээлэх үүрэгтэй ажилтны аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.
- 7.4 ГоАМЛ порталыг ашиглах хэрэглэгчийн нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх, бүртгэлтэй хэрэглэгч өөрчлөгдсөн тохиолдолд мэдээллийг шинэ хэрэглэгчээр яаралтай солих болон ГоАМЛ порталыг СМА-д мэдээлэл ирүүлэх журамд зааснаар бусдаар ашиглахгүй байх.
- 7.5 Энэ журмын хэрэгжилтэнд комплайнс хариуцсан ажилтнаар дамжуулан ТУЗ хяналт тавина.
- 7.6 МУТС-тэй тэмцэх тухай хуулийн дагуу данс, гүйлгээг царцаах, сэжиглэхтэй холбоотой мэдээллийг эрх бүхий байгууллагын ажилтнаас бусад аливаа хувь хүн, хуулийн этгээдэд задруулж үл болно.
- 7.7 Энэ журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
